



**“ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ  
БАЙГУУЛАМЖ” ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН  
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/01

Дорноговь аймаг, Замын-Үүд сум

**Тариф шинэчлэн тогтоох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын агуулахад хадгалагдах газрын тосны бүтээгдэхүүний нэг сард хадгалах савны хөлсийг 2000М<sup>3</sup> багтаамжтай нэг сав 30,000,000 /гучин сая/ төгрөг, 3000М<sup>3</sup> багтаамжтай нэг сав 45,000,000 /дөчин таван сая/ төгрөг, 5000М<sup>3</sup> багтаамжтай нэг сав 75,000,000 /далан таван сая/ төгрөгөөр тус тус хадгалахаар тогтоосугай.
2. Нарийн царигаар нийлүүлэгдэх газрын тосны бүтээгдэхүүний хадгалах хөлсийг нэг хоногт тонн тутамд 700 /долоон зуун/, шилжүүлэн ачилт 15000 /арван таван мянга/ төгрөгөөр тогтоосугай.
3. Энэхүү тушаалыг шинэчлэн баталж байгаатай холбогдуулан 2020 оны 01 дүгээр сарын 10-ний өдрийн А/04 тушаалыг хүчингүйд тооцсугай.
4. Тушаалыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хяналт тавьж ажиллахыг Ерөнхий нягтлан бодогч /Б.Дэлгэрдалай/-д даалгасугай.

ЗАХИРАЛ  Г.ГАНСҮХ

